

1. 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн мэргэжилтнүүд Г.Оюунцэцэг, Б.Пүрэвжав, Уянга, ЭМГ-ын ЭТХ-ийн чанар, магадлангийн асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Анжелика нар Хилийн цэргийн 0165 дугаар ангийн эмнэлгийг магадлан итгэмжлэлд оруулж өгөх тухай ЭМЯ-нд хүргүүлсэн хүсэлтийн дагуу тус эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажилд урьдчилсан үнэлгээ хийж, арга зүйн зөвлөлгөөгөөр хангаж ажиллав. Мөн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, ”Нур- Алтай”, ”Жан-Шарапат” хувийн ортой эмнэлгүүдийн үйл ажиллагаатай танилцаж, магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ хийв.

2. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсээс Эрүүл мэндийн тусламжийн чанар, өвчтөний аюулгүй байдал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр 1,5 кредиттэй сургалт, уулзалтыг ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн хэлтэстэй хамтран 2018 оны 10 дугаар сарын 2,3-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтанд аймгийн ЭМГ-ын харьяа төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал хариуцсан эмч, мэргэжилтэн, ёс зүйн салбар хорооны гишүүд нийт 50 хүн оролцов.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 57

Амьд төрөлт - 56

Амьгүй төрөлт - 1

Дутуу төрөлт - 0

Нялхсын эндэгдэл - 0

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл - 0

Эхийн ноцтой хүндрэл - 0

Төрөлхийн гажиг - 0

Гэрийн төрөлт - 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 39 дүгээр долоо хоногт нийт 3056 хүн үйлчлүүлсний 87(2.8%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.5%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (108)-ийн дотор 16 буюу 14,8 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 5,7%-иар буурсан үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 271 дуудлагын 22 (8,1%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 4,2%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 39 дүгээр 7 хоногт аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 17(94,4%) удаа ирүүлсэн байна.